



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/135

Алтай хот

“Нээлттэй Алтай” арга хэмжээг зохион
байгуулахад хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Монгол Улсын Их хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 4.2, 4.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 73 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тэргүүлэх чиглэл “Сумдын шинэчлэл-Хөдөөгийн хөгжил” төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засгийн газраас зохион байгуулж байгаа “Хөдөөгийн сэргэлт чуулга”-нд оролцох, Улаанбаатар хот болон төв суурин газраас Говь-Алтай аймагт шилжин ирж суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийг дэмжих цогц арга хэмжээний хүрээнд “Нээлттэй Алтай” арга хэмжээг зохион байгуулахад 12,912,495 (арван хоёр сая есөн зуун арван хоёр мянга дөрвөн зуун ерэн тав) төгрөг зарцуулсугай.

2. Шаардагдах 12,912,495 (арван хоёр сая есөн зуун арван хоёр мянга дөрвөн зуун ерэн тав) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР